



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/78

Мандалговь

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөнөөс
Орон нутгийн төсөвт төвлөрсөн мөнгийг
зарцуулах тухай

Монгол Улсын “Цэргийн албаны тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 8, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын хавсралт “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийг зарцуулах журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хилийн цэргийн 0129 дүгээр ангиас Дундговь аймагт гэрээт хилчин сурталчлах арга хэмжээнд ирсэн офицер, ахлагч нийт 25-н алба хаагчийн байр, хоолны зардлыг цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс орон нутгийн төсөвт төвлөрсөн хөрөнгөнөөс мөнгөн төлбөрийг зарцуулах журмын дагуу зарцуулахыг аймгийн Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д үүрэг болгосугай.

2. Тус арга хэмжээнд шаардагдсан 2.297.500 (хоёр сая хоёр зуун ерэн долоон мянга таван зуун) төгрөгийг дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийг зарцуулах журмын 4.1.9 заалтыг үндэслэн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Энхмарт)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150171